



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

АХУЙН  
Тамгын тэмдэг  
Тогтоолов  
Эрэг зургаах  
Тамгын тэмдэг З.Ф. &  
Э.С.Д. А.Б  
2013 оны 09 сарын 19 өдөр  
2013.09.29

Дугаар 119

Эрэгний

Өрхийн эрүүл мэндийн төвд төлбөртэй  
тусламж үйлчилгээ үзүүлэх журам батлах тухай

Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх төвлөрлийг сааруулах зорилгоор Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 г 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Өрхийн эрүүл мэндийн төвд төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлэх журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэх, шинжилгээнд иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, биелэлтийн явцыг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг Эрүүл мэндийн газрын дарга Г.Ганхуягт даалгасугай.

ДАРГА

Б.МЯГМАРСҮРЭН

## Өрхийн эрүүл мэндийн төвд төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлэх журам

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Өрхийн эрүүл мэндийн төвөөс иргэдэд оношлогоо, шинжилгээг ашгийн бус нөхцөлөөр төлбөртэй үзүүлэхэд оршино.

1.2. Төлбөртэй тусламж үйлчилгээ гэдэгт Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан тусламж үйлчилгээний үнэ хамаарах бөгөөд иргэд төлбөрөө төлж үйлчлүүлнэ

1.3. Бүх орлого нь байгууллагын кассаар дамжин байгууллагын дансанд орно.

### ХОЁР. Төлбөртэй үзүүлэх тусламж үйлчилгээний шаардлага

#### 2.1. Нийтлэг:

2.1.1. Төлбөртэй үзүүлж байгаа бүх шинжилгээ, үйлчилгээг нэр тус бүрээр нь төлбөрийн хэмжээг бичиж тэмдэглэсэн, тамгатай, үйлчлүүлэгчээр гарын үсэг зуруулсан баримттай байна.

#### 2.2. Өрхийн эрүүл мэндийн төв нь:

2.2.1. Шинжилгээ авах өрөөний бэлэн байдлыг хангаж ажиллана.

2.2.2. Шинжилгээний явцад гарсан эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлыг эрүүл мэндийн сайдын 2010 оны 158, 305, 179, 165 тоот тушаалыг баримтлан халдваргүйжүүлж устгана.

2.2.3. Эмч ажилчдыг лабораторын шинжилгээний болон оношлогооны чиглэлээр дагалдуулан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна. *(дөрвөн сая 1 хаяг төрөөр төлбөрөөр)*

2.2.4. Урвалж болон оношлуурын тасралтгүй байдлыг хангаж ажиллана

2.2.5. Төлбөрт шинжилгээ, оношлогоо хийлгэсэн үйлчлүүлэгч бүрт тасалбар өгөж үйлчилнэ. *(хэл нэрээр)*

2.2.6. Дотоод, гадаад шинжилгээний чанарын хяналтыг тогтмол хийж байна. *(тогтмол х-х, ГЗ/ӨЗ/Х-Х)*

2.2.7. Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга шинжилгээний чанарын баталгааг хариуцна. *(В;С-2 ! өрөө-х, хон шүү шүүтэй)*

2.2.8. Эмч нар шинжилгээний хариуг иргэд, үйлчлүүлэгчдэд тодорхой тайлбарлаж өгнө. (баримжаалсан гэж хэдхэн)

2.2.9. Аймгийн лабораторын ерөнхий мэргэжилтэнтэй тогтмол холбоотой ажиллаж мэргэжил арга зүйгээр ажилчдыг тасралтгүй хангана. ?

2.2.10. Төлбөрт тусламж үйлчилгээний үнэ тариф болон жагсаалтыг лабораторийн шинжилгээ авах өрөө, лавлагаа самбар, эмч нарын өрөөнд иргэдэд ил тод байрлуулсан байна. ✓

2.2.11. Шинжилгээ авах тоног төхөөрөмжийн баталгаажилтыг тогтмол хийлгэж байна.

2.2.12. Шинжилгээтэй холбоотой санхүүгийн тайланг улирал тутам Эрүүл мэндийн газарт тайлагнана. ?

### 2.3. Эрүүл мэндийн газар нь:

2.3.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн шинжилгээний чанар аюулгүй байдлын явцын хяналтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

2.3.2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

2.3.3. Шинжилгээ оношлогоотой холбоотой сургалт болон дагалдан сургалтыг зохион байгуулна.

2.3.4. Шаардлагатай мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэст хүргүүлж ажиллана.

### ГУРАВ. Бусад

3.1. Аймгийн ИТХ-аас баталсан төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалтан тусгагдаагүй оношлогоо, шинжилгээг төлбөртэй үзүүлэхгүй.

3.2. Энэхүү журмыг 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллана.